ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2024/24/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2024 он | Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас: 99013699 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нарантуул<br>Утас:99019800 Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024-02-19 № 1/29
танай 2024-01-29-ны № 09 -т

ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Н.МӨНХЗУЛ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2023 оны 04,05,06,07,08 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх төлбөрийн арга, багц, төлбөрийн хэмжээ, тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах зэрэг журмыг шинэчлэн баталсан байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтээр 553.2 сая төгрөгийг авч, 14.3 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч авлагаар бүртгэсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Эрдэнэбүрэн сумын эрүүл мэндийн төв нь тайлант онд 5 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 94 хувийн биелэлттэй гэж дүгнэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

*Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу* илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **46,610,409.09** | **77,645,567.83** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 8,816,710.00 | 2,778,911.89 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 8,816,710.00 | 2,778,911.89 |
| **3121** | **Төгрөг** | 8,816,710.00 | 2,778,912.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 8,816,710.00 | 2,778,912.00 |
| **33** | **АВЛАГА** | 6,039,364.24 | 15,966,169.78 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 898,645.37 | 898,645.37 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 14,383,865.00 |
| **335** | **Бусад авлага** | 5,140,718.87 | 683,659.41 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 4,457,059.46 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 683,659.41 | 683,659.41 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 31,754,334.85 | 58,900,486.06 |
| **351** | **Түүхий эд материал** | 14,652,801.90 | 35,662,544.95 |
| 35130 | Эм боох материал | 14,652,801.90 | 35,662,544.95 |
| **354** | **Хангамжийн материал** | 16,458,532.95 | 21,612,941.11 |
| 35420 | Аж ахуйн материал | 11,031,979.95 | 5,509,267.95 |
| 35460 | Хүнсний материал | 5,116,553.00 | 2,515,737.50 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 310,000.00 | 13,587,935.66 |
| 35600 | Мал амьтад | 643,000.00 | 1,625,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **387,210,967.82** | **408,182,889.31** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 387,210,967.82 | 408,182,889.31 |
| **392** | **Биет хөрөнгө** | 372,130,967.90 | 393,227,889.43 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 298,918,909.00 | 298,918,909.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (45,465,847.31) | (56,097,705.59) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 85,701,988.00 | 85,701,988.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (40,068,761.06) | (50,163,586.19) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 137,721,672.36 | 203,656,851.36 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (77,333,694.74) | (101,253,628.16) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 46,303,763.37 | 47,961,240.55 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (33,647,061.72) | (35,496,179.54) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 15,079,999.92 | 14,954,999.88 |
| 39301 | Программ хангамж | 1,250,000.00 | 1,250,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (250,000.08) | (375,000.12) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 14,080,000.00 | 14,080,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **433,821,376.91** | **485,828,457.14** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **63,590.27** | **282,332.54** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 63,590.27 | 282,332.54 |
| **413** | **Өглөг** | 63,590.27 | 282,332.55 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 63,590.27 | 226,818.49 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 55,018.06 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 496.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 496.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **433,757,786.64** | **485,546,124.60** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 433,757,786.64 | 485,546,124.60 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 201,605,647.02 | 201,605,647.02 |
| 51101 | Өмч: - төрийн | 201,605,647.02 | 201,605,647.02 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 131,906,247.38 | 183,694,585.34 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 131,906,247.38 | 127,093,830.29 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 56,600,755.05 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 100,245,892.24 | 100,245,892.24 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **433,821,376.91** | **485,828,457.14** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **556,057,346.80** | **692,792,184.59** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **53,728,863.80** | **83,090,560.93** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 53,728,863.80 | 83,090,560.93 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 53,728,863.80 | 83,090,560.93 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 370,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 53,358,863.80 | 83,090,560.93 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **502,328,483.00** | **609,701,623.66** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 990,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 990,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 31,525,283.00 | 30,940,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 31,525,283.00 | 30,940,700.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | - | 10,205,000.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 10,205,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 470,803,200.00 | 567,565,923.66 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 470,803,200.00 | 567,565,923.66 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **529,696,615.88** | **636,170,336.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **529,696,615.88** | **636,170,336.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 529,696,615.88 | 632,236,792.48 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 302,960,337.00 | 377,365,173.00 |
| 210101 | Үндсэн цалин | 199,766,491.00 | 240,722,034.00 |
| 210102 | Нэмэгдэл | 87,402,447.00 | 104,214,150.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,782,000.00 | 4,490,000.00 |
| 210104 | Урамшуулал | 13,009,399.00 | 27,938,989.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,078,370.31 | 47,102,710.69 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,122,991.30 | 32,524,289.74 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,071,895.87 | 3,823,151.73 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,457,516.69 | 3,036,521.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 578,815.13 | 620,331.09 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,847,151.32 | 7,098,416.74 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,577,511.06 | 26,993,720.16 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,834,196.90 | 2,182,338.32 |
| 210302 | Түлш, халаалт | 24,589,924.16 | 24,589,931.84 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 153,390.00 | 221,450.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,681,805.00 | 34,008,935.49 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,453,615.00 | 3,188,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,550,700.00 | 20,023,795.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,312,740.00 | 2,751,812.49 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 818,950.00 | 1,854,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 518,800.00 | 6,190,778.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 27,000.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 77,487,991.90 | 86,069,480.78 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 67,060,394.00 | 72,030,044.38 |
| 210502 | Хоол, хүнс | 9,233,597.90 | 12,719,436.40 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,194,000.00 | 1,320,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,973,666.65 | 1,856,832.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,386,000.00 | 577,032.00 |
| 210602 | Тавилга | 41,666.65 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 5,596,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 950,000.00 | 1,279,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,435,300.00 | 1,388,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,435,300.00 | 1,388,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 405,000.00 | 2,078,222.22 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 1,209,772.22 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000.00 | 354,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 80,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 25,000.00 | 14,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 300,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 120,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 47,096,633.96 | 55,373,718.14 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,395,945.00 | 12,743,974.78 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 33,700,688.96 | 42,629,743.36 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 3,933,544.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 497,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 497,200.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 3,436,344.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,436,344.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **26,360,730.92** | **56,621,848.11** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 998,958.55 | 21,093.06 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 998,958.55 | 21,093.06 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (998,958.55) | (21,093.06) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **25,361,772.37** | **56,600,755.05** |

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 201,605,647.02 | 100,245,892.24 | 131,906,247.38 | 433,757,786.64 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **201,605,647.02** | **100,245,892.24** | **131,906,247.38** | 433,757,786.64 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **201,605,647.02** | **100,245,892.24** | **131,906,247.38** | 433,757,786.64 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **201,605,647.02** | **100,245,892.24** | **131,906,247.38** | 433,757,786.64 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **201,605,647.02** | **100,245,892.24** | **131,906,247.38** | 433,757,786.64 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | (4,812,417.09) | (4,812,417.09) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 56,600,755.05 | 56,600,755.05 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **201,605,647.02** | **100,245,892.24** | **183,694,585.34** | 485,546,124.60 |

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **529,839,983.00** | **595,317,758.66** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **370,000.00** | - |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 370,000.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 370,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 370,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **529,469,983.00** | **595,317,758.66** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 990,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 990,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 31,525,283.00 | 30,940,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 31,525,283.00 | 30,940,700.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | - | 10,205,000.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 10,205,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 497,944,700.00 | 553,182,058.66 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 497,944,700.00 | 553,182,058.66 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **522,818,185.23** | **600,858,356.77** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **522,818,185.23** | **600,858,356.77** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **522,818,185.23** | **597,422,012.77** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 299,011,602.81 | 372,006,655.58 |
| 210101 | Үндсэн цалин | 184,000,516.94 | 230,001,370.74 |
| 210102 | Нэмэгдэл | 88,427,868.65 | 104,243,224.07 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,887,000.00 | 5,366,392.77 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 20,696,217.22 | 32,395,668.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,588,300.00 | 52,298,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,684,300.00 | 35,562,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,971,700.00 | 4,183,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,385,200.00 | 3,347,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 595,300.00 | 836,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,951,800.00 | 8,368,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 28,387,090.00 | 25,906,291.22 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,643,900.00 | 2,027,135.22 |
| 210302 | Түлш, халаалт | 26,489,800.00 | 22,935,556.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 253,390.00 | 943,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,543,882.52 | 30,008,712.97 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,547,915.00 | 2,965,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,205,477.52 | 19,982,390.48 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,192,840.00 | 2,751,812.49 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,438,550.00 | 2,138,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,159,100.00 | 2,170,660.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 97,752,424.90 | 81,208,966.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 81,354,076.90 | 70,413,345.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,108,248.00 | 9,475,621.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,290,100.00 | 1,320,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,360,000.00 | 7,946,064.78 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,096,000.00 | 4,500,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,305,900.00 | 1,848,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 958,100.00 | 1,598,064.78 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,435,300.00 | 1,388,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,435,300.00 | 1,388,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,685,000.00 | 2,018,222.22 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,280,000.00 | 1,209,772.22 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000.00 | 354,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 80,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 25,000.00 | 14,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 300,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 60,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,054,585.00 | 24,641,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,054,585.00 | 24,641,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | **3,436,344.00** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 3,436,344.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,436,344.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **7,021,797.77** | **(5,540,598.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 7,021,797.77 | (5,540,598.00) |

| | | | |
|---|---|---|---|
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 8,816,710.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 8,816,710.00 | 2,778,911.89 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 667,737,300 | 597,919,212.77 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 667,737,300 | 597,919,212.77 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 666,737,300 | 597,422,012.77 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 418,382,000 | 372,006,655.58 |
| 210101 | Үндсэн цалин | 266,503,100 | 230,001,370.74 |
| 210102 | Нэмэгдэл | 115,821,900 | 104,243,224.07 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,808,000 | 5,366,392.77 |
| 210104 | Урамшуулал | 30,249,000 | 32,395,668.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 52,298,000 | 52,298,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,562,700 | 35,562,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,183,700 | 4,183,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,347,200 | 3,347,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 836,200 | 836,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,368,200 | 8,368,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,570,500 | 25,906,291.22 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,137,100 | 2,027,135.22 |
| 210302 | Түлш, халаалт | 26,489,800 | 22,935,556.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 943,600 | 943,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 37,759,100 | 30,008,712.97 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,300,300 | 2,965,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,146,900 | 19,982,390.48 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,975,000 | 2,751,812.49 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,086,900 | 2,138,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,250,000 | 2,170,660.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 91,742,300 | 81,208,966.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 81,572,900 | 70,413,345.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,298,300 | 9,475,621.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,871,100 | 1,320,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,988,100 | 7,946,064.78 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,500,000 | 4,500,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,000,000 | 1,848,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,488,100 | 1,598,064.78 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,700,000 | 1,388,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,700,000 | 1,388,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,159,000 | 2,018,222.22 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,454,000 | 1,209,772.22 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000 | 354,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000 | 80,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 25,000 | 14,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 300,000 | 300,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 500,000 | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 300,000 | 60,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21,138,300 | 24,641,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,138,300 | 24,641,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,000,000 | 497,200.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,000,000 | 497,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000 | 497,200.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 667,737,300 | 591,881,414.66 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 31,058,600 | 27,504,356.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 31,058,600 | 27,504,356.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 617,656,900 | 553,182,058.66 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 617,656,900 | 553,182,058.66 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 19,021,800 | 11,195,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,205,000 | 11,195,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 8,816,800 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **8,816,710.00** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **2,778,911.89** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 22 | 22 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16 | 16 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4 | 4 |
| 620004 | Гэрээт ажилтан | 1 | 1 |
| **64** | **ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО** | - | 1,177 |
| 640001 | Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо | | 383 |
| 640002 | Улсын эмнэлгийн амбулаториор эмчлүүлэгсдийн тоо | | 794 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **22** | **22** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 17 | 16 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 5 | 6 |

## ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 462,232.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 452,418.4 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа[1]-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- ЭМД-ын сангийн санхүүжилт, ажилчидтай холбоотой авлагыг 804.1 мянган төгрөгөөр илүү,
- Үнэ төлбөргүйгээр ирсэн бараа материалыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг 2,973.3 мянган төгрөгөөр дутуу,
- Мөнгөн гүйлгээний тайланд хандив тусламжийн орлогыг 376,261.7 мянган төгрөгөөр илүү,
- Санхүүгийн үр дүнгийн тайланд эмч ажилчдад 2,552.0 мянган төгрөгөөр хөдөлмөр хамгааллын хувцсыг худалдан авч цалингийн зардалд тусгасан,
- Үнэ төлбөргүй шилжиж ирсэн болон худалдан авсан 1,849.3 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн,
- Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 32,773.9 мянган төгрөгөөр дутуу,
- Өмнөх оны элэгдлийн зардлыг 4,812.4 мянган төгрөгөөр өмнөх үр дүн дансанд бичээгүй, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан,
- Тайлант үеийн үр дүнг 30,391.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан.

Залруулагдаагүй нийт 9,947.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 9,813.8 мянган төгрөгийн 4 зөрчил[2] илэрснээс, 5,699.8 мянган төгрөгийн төлбөрийн акт, 4,114.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

**3.1 Төлбөрийн акт**

1. Эмч ажилчдад илүү цагийн нэмэгдлийг зөрүүтэй, батлагдаагүй орон тоонд ажил хавсарсны нэмэгдэл, түлээ нүүрсний хөнгөлөлт, эрүүл мэндийн шинжилгээний төлбөрт нийт 5,699.8 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заасантай тус тус нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төлбөрийн акт тогтоосон

**3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**3.2.1. Зардлын данстай холбоотой асуудал**

***<u>Илрүүлэлт:</u>*** Эрүүл мэндийн төвийн стандартад заагдаагүй тоног төхөөрөмж худалдан авсан, тусгай зөвшөөрөлгүй байгууллагаас оношлуур худалдан авсан, эмч ажилчдад түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй, Ариун гантиг ХХК-д 2022-2023 онд эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, засвар үйлчилгээ хариуцан хамтран ажиллах гэрээ байгуулан төлбөрийг шилжүүлсэн ямар ажил хийж гүйцэтгэсэн эсэх нь тодорхой бус байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;”, 16.5.5-д “батлагдсан төсвийг

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зориулалтын дагуу зарцуулах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны MNS5081:2013 стандартын C хавсралтад "сум тосгоны Эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлийн багаж хэрэгсэл тоног төхөөрөмж" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын ЭМТ-ийн стандартыг мөрдөн ажиллах, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх

### *3.2.2 Газартай холбоотой асуудал*

***Илрүүлэлт:***

Байгууллагын санхүүгийн тайлан балансад тусгасан газар 7040 м2 хэмжээ, газрын кадастрийн зургаар 5437 м2 хэмжээ зөрүүтэй 1603 м2-аар зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.
нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Газрын асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлэх

### 3.2.3 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

***Илрүүлэлт:*** Үндсэн хөрөнгийн бүртгэлд 2011 онд ашиглалтад орсон 6 ширхэг мотоциклуудыг ашиглах боломжгүй, бодитоор оршин байхгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана:" 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/; ", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны 65 дугаар тогтоолоор "Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Ашиглагдахгүй байгаа хөрөнгийн асуудлыг аймгийн Орон нутгийн газарт уламжлан шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** / мян.төгрөг/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төв | 8 | 452,418.4 | | | 8 | 452,418.4 | 8 | 452,418.4 | - | - | - | - |
| Дүн | 8 | 452,418.4 | - | - | 8 | 452,418.4 | 8 | 452,418.4 | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** / мян.төгрөг/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төв | 4 | 9,813.8 | 1 | 5,699.8 | | | 3 | 4114 | - | - | - | - |
| Дүн | 4 | 9,813.8 | 1 | 5,699.8 | 0 | - | 3 | 4114 | - | - | - | - |

**ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | ТШЗ | - | 1 | - | - | 1 | - | - | - |
| НИЙТ | | | 1 | - | - | 1 | - | - | - |